



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 0/102.

Улаанбаатар хот

「Баянзүрх дүүргийн “Нийтлэг үйлчилгээний газар нэг” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын данс бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/606 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Техникийн комиссын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдахаар шийдвэрлэгдсэн нийт 66,800,000.00 (жаран зургаан сая найман зуун мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 4 тээврийн хэрэгслийг хавсралтын дагуу данс бүртгэлээсээ хасахыг Баянзүрх дүүргийн “Нийтлэг үйлчилгээний газар нэг” ОНӨААТҮГ (Д.Өлзийдэмбэрэл)-т зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлтийг хийж, тээврийн хэрэгслийн гэрчилгээ улсын дугаарыг хураан авч авч авто тээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс хасуулахыг “Нийтлэг үйлчилгээний газар нэг” ОНӨААТҮГ (Д.Өлзийдэмбэрэл)-т үүрэг болгосугай.

3.Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (М.Мөнхбаяр), тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т тус тус даалгасугай.


ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150500457

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2024 оны ... дугаар сарын ...-ны
өдрийн ... дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах тээврийн хэрэгслийн жагсаалт

№	Автомашины марк	Улсын дугаар	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
1	Хьюндай HD72	05-08 УНП	16,800,000.00	16,800,000.00	0.00
2	Хьюндай Mighty-11	05-11 УНП	16,800,000.00	16,800,000.00	0.00
3	Hyundai HD120	05-19 УНП	16,600,000.00	16,600,000.00	0.00
4	Киа бонго	07-85 УНД	16,600,000.00	16,600,000.00	0.00
Дүн			66,800,000.00	66,800,000.00	